



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Манлай сумын Засаг даргын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: **ӨМА-2022/13/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: khongorzult@audit.gov.mn

Аудитор: Н.Хулан

Утас: 70533552 Цахим хаяг: khulann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу

Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Өмнөговь аймгийн Манлай сумын Засаг даргын үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Засаг даргын ажлын албаны үйл ажиллагааны шуурхай найдвартай, ил тод байдал манлайллыг ханган иргэддээ төрийн үйлчилгээг хүнд сурталгүй, ил тод түргэн шуурхай хүргэж гүйцэтгэл үр дүнд чиглэсэн удирдлагын тогтолцоо бүхий жишиг үйл ажиллагаатай Тамгын газар байхад оршино.” гэж тодорхойлжээ.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/төгрөгөөр/
Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,853,181,431.68
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	19,899,420,231.97
	Нийт хөрөнгийн дүн	<u>21,752,601,663.65</u>
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	21,752,601,663.65
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	5,207,607,873.47
	Үйл ажиллагааны зардлын дүн	4,294,980,970.89
	Үйл ажиллагааны үр дүн	912,626,902.58
	Үйл ажиллагааны бус үр дүн	253,138,728.68
	Үйл ажиллагааны нийт үр дүн	659,488,173.90
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	17,783,238,440.62
	Тайлант оны үр дүн	659,488,173.90
	Эцсийн үлдэгдэл	18,442,726,614.52
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	4,643,226,901.02
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	3,898,511,331.06
	Үйл ажиллагааны ЦМГ	<u>744,715,569.96</u>
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	<u>-359,355,052.00</u>
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	385,360,517.96
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	673,087,342.29
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	1,058,447,860.25
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,265,442,100.00
	Урсгал зардал	2,653,356,500.00
	Хөрөнгийн зардал	612,085,600.00
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	3,265,442,100.00
	Улсын төсвөөс санхүүжих	1,573,033,300.00
	Орон нутгийн төсвөөс	1,034,234,600.00
	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	25,903,100.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	632,271,100.00

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1			1			
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
НИЙТ									

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитын явцад шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгаж үзэхэд тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Тав. Аудитын үр дүн

5.1 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	3	134.9	3	134.9						
2	ТТЗ										
3	ТЕЗ										
НИЙТ											

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 134.9 сая төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснийг аудитын явцад залруулсан.

Зургаа. Аудитын санал дүгнэлт /баталгаажсан хувийг оруулах/



**ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

МАНЛАЙ СУМЫН ЗАСАГ ДАРГА
П.БААСАНЦОГТ ТАНАА

2022.07.24 № 286

тавай _____-ны № _____-т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Манлай сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Манлай сумын Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ЦЭРЭНБАЯР